



ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫГ ХҮРГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА: ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

OPERATION OF HANDLING STATE AND OFFICIAL SECRETS: SOME ISSUES

Сүхбаатарын Сэргэлэн¹
Бадарчийн Нармандах²

Shihihutug University, E-mail: narmandakh@shihihutug.edu.mn, <https://orcid.org/0009-0004-1986-2361>

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

ХУРААНГУЙ

Түлхүүр үгс:

үндэсний аюулгүй байдал,
төрийн болон албаны нууц,
нууцыг хүргэх, хууль зүйн
реализм, мэдээллийн аюулгүй
байдал

Keywords:

national security, state and
official secrets, disclosure of
secrets, legal realism,
information security

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2025, 8 сар
Шинэчилсэн: 2025, 9 сар
Зөвшөөрсөн: 2025, 10 сар

Article history:

Received Aug, 2025
Revised Sep, 2025
Accepted Oct, 2025


Энэхүү судалгаа нь Монгол Улсын төрийн болон албан ёсны нууцын тухай хууль болон түүний хэрэгжилт, тэр дундаа, төрийн болон албан ёсны нууцыг хүргэх үйл ажиллагааны эрх зүйн орчныг үндэсний аюулгүй байдлын цогц байдлын онол болон эрх зүйн реалист хандлагаар үнэлж, эрх зүйн зохицуулалт болон практик хэрэгжилтийн хоорондох зөрүүг тодорхойлсон. Судалгааны дүнгээс харахад хууль, эрх зүйн орчин оршин байгаа ч байгууллагын чадавх, хүний хүчин зүйл, аюулгүй байдлын соёлын ялгаанаас шалтгаалан үр нөлөө нь хязгаарлагдмал байна.

Нууцыг гадаадад дамжуулах журам байхгүй, төрийн тусгай иүүдангийн үйлчилгээний чадавх хязгаарлагдмал зэрэг нь эмзэг байдлыг бий болгож байна. Иймд эрх зүйн зохицуулалтыг үндэсний аюулгүй байдлын зорилттой уялдуулах шаардлагатайг оңцолсон.

Abstract

This study examines Mongolia's Law on State and Official Secrets and its implementation, focusing on the legal framework for transmitting state and official secrets. Applying comprehensive national security theory and legal realism, it identifies gaps between formal regulations and practical enforcement. Findings show that while the legal framework exists, its effectiveness is limited by institutional capacity, human factors, and variations in security culture. The lack of formal procedures for transmitting secrets abroad and the limited capabilities of the state special postal service create vulnerabilities. From a legal realist perspective, law operates through institutional capacity and implementers' behavior. The study highlights the need to align legal regulations with national security objectives to strengthen information integrity and the protection of state secrets.

Энэ өгүүлэл [CC BY-NC](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/) лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



¹ Шихихутуг их сургуулийн магистрант

² Хууль зүйн доктор (Ph.D), профессор, Шихихутуг их сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүн.

1. Танилцуулга

Энэхүү өгүүлэлд Монгол Улсад мөрдөгдөж буй Төрийн болон албаны нууцын тухай хууль болон холбогдох журам, тэдгээрийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, төрийн болон албаны нууцыг хүргэх үйл ажиллагааны эрх зүйн орчны тулгамдсан асуудлыг үндэсний аюулгүй байдлын цогц байдлын онол болон хууль зүйн реалист хандлагаар үнэлсэн болно. Судалгаанд хууль зүйн догматик, реалист, харьцуулсан шинжилгээний аргуудыг хослуулан ашиглаж, эрх зүйн зохицуулалтын формаль бүтэц ба бодит хэрэгжилтийн зөрүү, эрх зүйн хийдэл байгааг тодорхойлсон.

2. Арга зүй

Хууль зүйн реализмын үүднээс бол хууль нь зөвхөн норматив хэлбэрээр бус, институтийн чадамж ба хэрэгжүүлэгчийн зан үйлийн уялдаанд тулгуурлан хэрэгжиж бодит үр нөлөөгөө үзүүлдэг. Иймд төрийн болон албаны нууцыг хүргэх үйл ажиллагааны эрх зүйн орчныг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдуулан, мэдээллийн бүрэн бүтэн байдал, төрийн нууцын хамгаалалтын үр нөлөөг нэмэгдүүлэх замаар боловсронгуй болгох шаардлага байгааг судалгаа харуулж байна.

3. Судалгааны үр дүн

Оршил

Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдлыг хангах нь аливаа улсын төрийн үндсэн үүрэг билээ. Төр, улсын аюулгүй байдлыг хамгаалахын тулд нийгэм, төрийн ашиг сонирхолд хор хохирол учруулж болзошгүй мэдээллийг нууцлах, хамгаалах тогтолцоо зайлшгүй шаардлагатай. Төрийн болон албаны нууцыг хадгалах, хамгаалах үйл ажиллагаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтолцооны мэдээллийн хамгаалалтын дэд систем бөгөөд нууцад хамаарах мэдээллийг боловсруулах, хадгалах, дамжуулах, хүргэх бүхий л шатанд аюулгүй байдлын нарийн зохицуулалт шаарддаг.

Өнөөдөр Монгол Улсад төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалттай холбоотой хууль эрх зүйн тогтолцоо бүрэлдсэн ч нууцад хамаарах мэдээллийг хүргэх үйл ажиллагаа, өөрөөр хэлбэл, илгээгчээс хүлээн авагчид аюулгүй, бүрэн бүтэн байдлаар хүргэх тогтолцоо, түүний эрх зүйн үндэс тодорхой бус байна.

Энэхүү өгүүллээр Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан нууцад хамаарах мэдээллийг хүргэхтэй холбоотой харилцааг норматив эрх зүйн зохицуулалтын хүрээнд органик түвшинд судлан Үндэсний аюулгүй байдлын онол болон хууль зүйн реализмын үүднээс үүсэж буй тулгамдсан асуудлыг тодорхойлон, аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр санал дэвшүүлэхийг зорьсон.

Арга зүйн хувь энэхүү судалгаанд төрийн болон албаны нууцыг хүргэх үйл ажиллагааны эрх зүйн орчныг үндэсний аюулгүй байдлын цогц байдлын онол болон хууль зүйн үүднээс шинжилгээ хийж, төрийн болон албаны нууцыг хүргэх үйл ажиллагааг мэдээллийн хамгаалалтын дэд системийн бүрэлдэхүүн болгон Үндэсний

аюулгүй байдлын цогц байдлын онолоор үнэлэх, төрийн болон албаны нууцыг хүргэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, бодит хэрэгжилт, институтийн чадавх, хүний хүчин зүйлийн нөлөө зэргийг хууль зүйн реализмын үүднээс тайлбарлахыг зорьсон.

Судалгаанд хууль зүйн догматик, реалист, харьцуулсан шинжилгээний аргуудыг хослуулан хэрэглэсэн. Үүнд:

- Төрийн болон албаны нууцын тухай хууль болон холбогдох журмуудын эрх зүйн зохицуулалтын бүтэц, агуулгыг догматик аргаар;
- тухайн хууль эрх зүйн зохицуулалтын бодит хэрэгжилт, төрийн тусгай шуудан болон дипломат шуудангийн үйл ажиллагаанд үүсэж буй институтийн сул тал, практик хүндрэл, хүний хүчин зүйлийн нөлөөг реалист аргаар;
- үндэсний зохицуулалтыг олон улсын жишиг болон мэдээллийн аюулгүй байдлын стандартуудтай харьцуулан үнэлэхэд харьцуулсан шинжилгээний аргыг хэрэглэсэн.

Судалгааны хүрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг илгээгчээс хүлээн авагчид хүргэх үе шат, түүнд оролцогч этгээдийн эрх зүйн байдал, хариуцлага, хяналт болон мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамарсан.

Төрийн болон албаны нууцыг хүргэх үйл ажиллагааны эрх зүйн орчны нийтлэг зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.17-д “...төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоож хамгаална”³ гэж заасан бөгөөд энэ заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 1995 онд анх Төрийн нууцын тухай хуулийг баталж, улмаар 2016 онд Төрийн болон албаны нууцын тухай хууль хэмээн шинэчлэн баталснаар 2017 оны 9 дүгээр сарын 1-нээс мөрдөж эхэлсэн.

Төрийн болон албаны нууцын тухай хуулиар албаны нууцыг тогтоох, хамгаалахтай холбоотой зохицуулалтыг бий болгож, төрийн нууцын зэрэглэл, нууцлах хугацаанд өөрчлөлт оруулан, төрийн болон албаны нууц хариуцсан байгууллага, албан тушаалтны үүрэг, хариуцлагыг шинэчлэн, аюулгүй байдлын шалгалт явуулж, албан тушаалтан, иргэнд нууцтай танилцах эрх олгодог болсон. Мөн төрийн болон албаны нууцыг ашиглан үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдэд “аюулгүй байдлын гэрчилгээ” олгох, түүнийг хүчингүй болгох, мөн нууцад хамаарах мэдээллийг гадаад улс, олон улсын байгууллагад шилжүүлэх, нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог тодорхой болгосон зэрэг олон шинэ зохицуулалтыг бий болгосон.⁴

³ *Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №01*

⁴ *Б.Батхшиг, “Монгол Улсын төрийн нууцын хадгалалт, хамгаалалтыг боловсронгуй болгох зарим асуудал” докторын судалгааны ажил (2022)*

Хууль зүйн догматик шинжилгээгээр авч үзвэл:

Тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Мэдээллийг нууцлах арга хэмжээг тэдгээрийг төрийн болон албаны нууцад хамааруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн холбогдох байгууллага, албан тушаалтан авч хэрэгжүүлнэ” гэж заасан.⁵ Хуульд заасан үндэслэл журмын дагуу төрийн болон албаны нууцад хамааруулсан мэдээллийг хариуцсан байгууллага, албан тушаалтан төдийгүй эрхлэх ажил, үүргийн дагуу нууцад хамаарах мэдээлэлтэй танилцсан иргэн, хуулийн этгээдийн хувьд нууцлах, түүнийг задруулахгүй байх нийтлэг үүрэг хүлээдэг. Хуульд заасан үндэслэл журмын дагуу нууцад хамааруулсан мэдээллийг нууцлах үйл ажиллагаа нь нууц мэдээллийг боловсруулах, танилцах, илгээх, хүргэх, дамжуулах, хяналт тавих зэрэг хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулахтай холбоотой өргөн цар хүрээтэй ойлголт юм.

Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-й хэсэгт “энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээ, баримт бичиг, эд зүйлийг битүүмжлэн хүргэх төрийн тусгай болон дипломат шуудан, битүүмжлэхээс хэрэглэгчид хүртэл үйл ажиллагаа” төрийн нууцад хамаарахаар заасан бөгөөд хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т төрийн нууцыг хилийн чанад дахь Монгол Улсын байгууллага, албан тушаалтанд илгээх, хүлээн авахад түүнийг биечлэн хүргэх тусгай шуудан зөөгч ашиглаж болохоор хуульчилсан бөгөөд “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 5 дугаар зүйлийн 5.3.10-т зөвхөн хот, суурин дотор нууц баримт бичгийг биечлэн хүргэхийг зохицуулсан байдаг.

Гэтэл хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт хилийн чанад дахь Монгол Улсын байгууллага, албан тушаалтанд тусгай шуудан хүргэх, хүлээн авахтай холбогдсон харилцааг гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, тагнуулын байгууллагын даргын хамтарсан тушаалаар баталсан тусгай журмаар зохицуулахаар заасан боловч энэ журам өнөөг хүртэл батлагдаагүй нь хот хооронд болон хилийн чанад дахь нууц баримт мэдээллийг хүргэх үйл ажиллагааны эрх зүй зохицуулалтгүй орчин үүсэж, мэдээллийн урсгалын хамгаалалтад эрсдэлт нөхцөл байдлыг бий болгож байна.

Эрх зүйн реалист онолын 6 үүднээс авч үзвэл, хууль өөрөө төгс байх нь хангалтгүй, харин хууль бодит харилцаанд амьдран хэрэгжиж, институцийн бодит чадавхтай нийцэж байж жинхэнэ үр нөлөөгөө үзүүлнэ.

Төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичиг, бусад нууц тээгчийг хүргэх тухай асуудал нь илгээгчээс хүлээн авагч талд хүргүүлж буй нууцад хамаарах мэдээллийг ямар нэг хөндлөнгийн нөлөөнд автуулахгүйгээр бүрэн бүтэн хүргэх тухай ойлголт бөгөөд төрийн тусгай болон дипломат шуудангаар хүргэх төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичиг, бусад нууц тээгчийг төрөлжүүлэн ангилж, тэдгээрээс

⁵ Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №11

⁶ Америкийн эрх зүйн философич Jerome Frank, Karl Llewellyn

төрийн нууцад хамаарах мэдээллийг биечлэн хүргэдэг байх нь үндэсний аюулгүй байдалд өндөр ач холбогдолтой мэдээллийг хамгаалах зайлшгүй шаардлага гэж үзэж байна.

Төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичиг, бусад нууц тээгч бүрийг төрийн тусгай шуудангийн албанаас биечлэн хүргэх нь нууц хамгаалах үндсэн шаардлага боловч тус нэгжийн хүний нөөц, төсөв, санхүүгийн боломжоос хамаарч ийм боломж хязгаарлагдмал байсаар байна. Иймд нууц хүргэх үйл ажиллагааг хуулийн нийтлэг шаардлага, зарчимд нийцүүлэн явуулах, институтийн болон хүний нөөцийн чадавх, техникийн аюулгүй байдал зэргийг хангах үйл ажиллагааг сайжруулах, нууцад хамаарах мэдээллийг хүргэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтыг боловсронгуй болгох нь үндэсний аюулгүй байдалд өндөр ач холбогдолтой мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, нууцад хамаарах мэдээлэл задарч, үрэгдэхээс урьдчилан сэргийлэх, үндэсний аюулгүй байдлыг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Өнөөгийн практикийг судлан үзвэл төрийн тусгай шуудангийн алба нь төрийн болон албаны нууцын хүргэлтэд голлох үүрэгтэй боловч хүний нөөц, санхүү, техник тоног төхөөрөмжийн хүрэлцээ хязгаарлагдмал байгаагаас төрийн болон албаны нууцад хамаарах баримт мэдээллийг хүргэх үйл ажиллагааг хувийн шуудангийн байгууллагаар дамжуулан гүйцэтгэдэг байна. Хувийн шуудангийн байгууллагууд шууд төрийн нууцын хамгаалалт хариуцах этгээд биш тул Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу “Аюулгүй байдлын гэрчилгээ” авсан байх шаардлага тавигддаг. Гэсэн ч эдгээр нь шууд төрийн нууц хамгаалах хариуцлага хүлээх этгээд биш юм. Энэ нь төрийн тусгай шуудангийн үйлчилгээний хязгаарлагдмал байдлыг харуулж байгаа бөгөөд төрийн нууцын хүргэлт хариуцсан институтийн чадавх аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь хууль зүйн реализмын үүднээс авч үзвэл, эрх зүйн зохицуулалт формаль түвшинд бүрэн мэт боловч, институтийн чадавхын хомсдол хууль хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж байна гэсэн дүгнэлтэд хүргэдэг. Хуульд заасан зохицуулалт нь бодит амьдрал дахь нөөц, чадавх, соёлын нөхцөлд нийцээгүйгээс хэрэгжих чадвар сул байгаа нь хууль зүйн үр нөлөөний нэгэн чухал саад болж байна.

Шуудангийн үйлчилгээ эрхэлдэг компанийн сүлжээгээр дамжуулан 2017 онд Төрийн тусгай шууданг орон нутгаас Улаанбаатар хот руу хүргэх явцад алдагдаж, шуудангийн богцонд байсан 3 төрлийн баримтаас зөвхөн хоёрыг нь шалгах ажлын явцад олж, нэгийг нь олоогүй тохиолдол гарсан⁷. Энэхүү асуудал нь төрийн тусгай шуудангийн албаны шуудангийн илгээмжийг биечлэн хүргэх боломж, чадавх сул байгаатай шууд холбоотой бөгөөд нууцад хамаарах мэдээллийг хүргэх эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатайг илтгэж байна.

⁷ Төрийн нууцын хэлтэс, 2017.

Британийн Батлан хамгаалах яамны Афганистанд хийгдэх цэргийн ажиллагааны нарийн төлөвлөгөө болон НАТО-гийн холбоотны байрлалуудын мэдээлэл агуулсан "TOP SECRET" зэрэглэлд хамаарах 50 гаруй хуудас баримт бичгийг 2021 онд тээвэрлэн хүргэх явцад Лондоны нэгэн автобусны буудлын ойролцоо алдсан ноцтой зөрчил гарсан⁸. Эдгээр мэдээлэл задарснаар Афганистанд байрлаж байсан НАТО-гийн болон Британийн цэргүүдийн байрлал, хөдөлгөөний замнал илчлэгдэж, террорист бүлэглэлүүдэд ашиглагдах бодит эрсдэл үүсэн, олон улсын хамтын ажиллагаа, итгэлцэлд сэв суусан зэрэг олон таагүй үр дагавар бий болсон. Мөрдөн шалгалтын үр дүнд энэхүү зөрчлийг тээвэрлэлтийн үеийн хамгаалалтын горим зөрчсөн гэж үзээд тээвэрлэлтийн журмыг шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байв.

Нөгөө талаас төрийн болон албаны нууцын хадгалалт, дамжуулалт нь үндэсний аюулгүй байдлын тогтолцооны мэдээллийн хамгаалалтын дэд систем мөн. Тиймээс үндэсний аюулгүй байдлын онолоор үнэлж үзвэл энэ нь төрийн мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах институтийн баталгаатай шууд холбоотой бөгөөд бүс нутгийн аюулгүй байдлын цогц онолын үндэслэгч Копенгагений их сургуулийн профессор Барри Бузан (Barry Buzan)-ы үзсэнээр мэдээллийн аюулгүй байдал нь төрийн нууц хамгаалалтын гол тулгуур мөн.⁹

Төрийн болон албаны нууцыг хүргэх үйл ажиллагаа нь үндэсний мэдээллийн аюулгүй байдлын гинжин хэлхээний нэг бүрэлдэхүүн болохын хувьд нууц мэдээлэл хүргэх явцад алдагдал гарвал төрийн шийдвэр гаргах чадамж сулрах, дипломат харилцаанд итгэл буурах, цэргийн болон технологийн мэдээлэл гадагш алдагдах эрсдэл үүснэ.

Б.Бузаны үзлээр, үндэсний аюулгүй байдал нь зөвхөн зэвсэгт хамгаалалт бус, институтийн тогтвортой ажиллагаанд тулгуурладаг. Тиймээс төрийн болон албаны нууц хүргэх үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтыг үндэсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн нэг хэсэг хэмээн авч үзэж, зөвхөн хууль зүйн хүрээнд бус, аюулгүй байдлын стратегийн баримт бичигтэй уялдуулан авч үзэх шаардлагатай.

Үндэсний аюулгүй байдлын онолын дагуу төрийн институт бүр “аюулгүй байдлын соёл”-той байх ёстой. Гэтэл нууц хүргэлт хариуцсан байгууллагуудын дунд энэ соёл ялгаатай, хариуцлага тодорхойгүй байна. Энэ нь мэдээллийн аюулгүй байдлын соёлын алдагдлыг илтгэнэ.

Монгол Улсад төрийн болон албаны нууц хүргэлтийн журам тодорхойгүй байдал нь мэдээллийн аюулгүй байдлын гинжин хэлхээнд цоорхой үүсгэж, төрийн шийдвэр гаргах чадвар, дипломат итгэлцэл, гадаад түншлэлд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна. Иймээс нууц хүргэлтийн эрх зүйн орчныг зөвхөн хууль зүйн хүрээнд биш, үндэсний аюулгүй байдлын бодлогын бүрэлдэхүүн хэсэг хэмээн авч үзэх шаардлагатай.

⁸ *BBC News, 2021.06.27, The Guardian, 2021.06.28*

⁹ *“People, States and Fear” бүтээлд үндэсний аюулгүй байдлыг цэргийн, улс төрийн, нийгмийн, эдийн засгийн, мэдээллийн таван хэмжээсээр авч үздэг.*

Энэ нь мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангах стратегийн бодлогын нэг хэсэг болж, төрийн мэдээллийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх суурь нөхцөл болно.

Гадаадын зарим улсад нууцад хамаарах мэдээллийг тээвэрлэн хүргэхтэй холбоотой хууль тогтоомжийн нарийвчилсан зохицуулалтыг бий болгож, нууцыг хүргэх үйл ажиллагааг тусгай эрх бүхий байгууллага, аюулгүй байдлын шаардлага хангаж буй албан хаагчдаар гүйцэтгүүлдэг, зохих шаардлага, стандартыг мөрддөг, өндөр зэрэглэлийн нууцад хамаарах мэдээллийг хоёроос доошгүй албан хаагчдаар биечлэн хүргүүлдэг зэрэг нууцлал, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн нийтлэг шаардлага ажиглагдаж байна. ХБНГУ-ын хувьд нууцад хамаарах мэдээллийг тээвэрлэн хүргэх үйл ажиллагааг зохион байгуулахдаа нарийвчилсан зохицуулалт бүхий хууль, журмын дагуу, нууцлал, аюулгүй байдлын өндөр стандартыг баримтлан, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлдгээрээ бусад орнуудаас онцгойлон ялгардаг.

4. Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс үзвэл, төрийн болон албаны нууц хүргэх үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлын мэдээллийн хамгаалалтын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангах үндсэн баталгаа юм.

Хууль, эрх зүйн акт нь бодит амьдрал дээр хэрэгжих боломжтой, нийгмийн хэрэгцээ, харилцааны онцлогт нийцсэн, үр нөлөөтэй, тодорхой байх ёстой эрх зүйн бодитой байх зарчмын шаардлагын дагуу мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж буй Төрийн болон албаны нууцын тухай хууль нь формаль түвшинд бүрэн гүйцэд мэт боловч, судалгаагаар төрийн болон албаны нууцыг хүргэх үйл ажиллагаанд эрх зүйн хийдэл, институтийн чадавхын сул тал, хүний хүчин зүйлийн доголдол, соёлын аюулгүй байдлын хомсдол зэрэг гол асуудлууд илэрсэн. Төрийн тусгай шуудангийн үйлчилгээний хүрэлцээ, хилийн чанад дахь хүргэлтийн журам тодорхойгүй байгаа нь мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоонд цоорхой үүсгэж байна.

Төрийн болон албаны нууц хүргэх үйл ажиллагааны эрх зүйн орчин нь формаль түвшинд бүрдсэн боловч хэрэгжилтийн бодит нөхцөл, институтийн чадавх, хүний хүчин зүйлийн улмаас эрх зүйн үр нөлөө сул гэж үзэн эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, төрийн болон албаны нууцыг хүргэх тусгай журам батлах, институтүүдийн чадавхыг нэмэгдүүлэх, хүний нөөцийн аюулгүй байдлын сургалт, хяналтыг тогтмолжуулах шаардлагатай. Энэ нь мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангаж, үндэсний аюулгүй байдлын мэдээллийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх чухал нөхцөл болно.

Үндэсний аюулгүй байдлын онолоор төрийн мэдээллийн нууцлал нь улс төрийн, эдийн засгийн, цэргийн аюулгүй байдлын үндсэн баталгаа бөгөөд институтийн түвшинд мэдээллийн хамгаалалтын гинжин хэлхээ бүрэн, найдвартай байх шаардлагатай. Монгол Улсад нууц хүргэлтийн журам бүрэн боловсроогүй, хилийн чанад дахь хүргэлтийн зохицуулалт батлагдаагүй, төрийн тусгай шуудангийн чадавх хязгаарлагдмал байгаа нь мэдээллийн аюулгүй байдлын цогц тогтолцоонд системийн цоорхой үүсгэж байна.

Барри Бузаны үзсэнчлэн, аюулгүй байдал нь зэвсэглэл төдийгүй институтийн найдвартай байдал, зохион байгуулалтын соёл-оор илэрдэг. Тиймээс төрийн болон албаны нууц хүргэлтийн эрх зүйн орчин нь зөвхөн хууль зүйн асуудал бус, үндэсний аюулгүй байдлын стратегийн бодлогын хэрэгжилтийн бүрэлдэхүүн гэж үзэх нь зүйтэй.

Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжид заасан нууцад хамаарах мэдээллийг бусад байгууллага, албан тушаалтанд хүргэх эрх зүйн зарим зохицуулалт тодорхой бус, харилцааг бүрэн зохицуулах боломжгүйн улмаас уг үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад шийдвэрлэх шаардлага бий болсон.

Нууц хүргэлтийн найдвартай байдал нь институтийн бүтэц, зохион байгуулалт, техник технологийн чадавх болон хүний хүчин зүйд хамааралтай. Судалгаагаар илэрсэн гол хүндрэл нь:

- төрийн тусгай шуудангийн байгууллагын санхүү, хүний нөөцийн хязгаарлагдмал байдал,
- нууц хүргэлтийн тусгай журам, аюулгүй байдлын стандартын дутмаг байдал,
- нууц хамгаалах хариуцлагын соёлын ялгаа, сургалт, үнэлгээний тогтолцооны сулрал зэрэг байв.

Эдгээр нь эрх зүйн орчныг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж, мэдээллийн аюулгүй байдлын соёлын алдагдлыг бий болгож байна. Иймд хууль зүйн реализмын хууль, байгууллагын чадамж, хэрэгжүүлэгчийн зан үйл гэсэн томъёоллын дагуу эрх зүйн үр нөлөөг институтийн бодит чадавх, хүний нөөцийн хариуцлага, соёлын түвшинтэй уялдуулан үнэлэх шаардлагатай.

Төрийн болон албаны нууцыг хүргэх үйл ажиллагаанд хамааралтай эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд: Нууц хүргэлтийн аюулгүй байдлыг хангахын тулд дараах чиглэлд анхаарах шаардлагатай:

1. Эрх зүйн зохицуулалтын түвшинд

- “Төрийн болон албаны нууцыг хүргэх журам”-ыг боловсруулж, хот хооронд болон хилийн чанад дахь хүргэлтийн нөхцөлийг тодорхой болгох;
- Нууц хүргэлтэд оролцож буй этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тогтоох.

2. Институтийн түвшинд

- Төрийн тусгай шуудангийн албаны хүний нөөц, санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх;
- Нууц хүргэхэд ашиглагдах тусгай тоног төхөөрөмж, битүүмжлэлийн системийг шинэчлэх, олон улсын стандартад нийцүүлэх.

3. Хүний нөөц ба сургалтын түвшинд

- Нууц хүргэлт, дипломат шуудан хариуцсан ажилтнуудад зориулсан аюулгүй байдлын стандарт сургалт болон хууль зүйн ухамсрын хөтөлбөрийг бий болгох.
- Нууц хамгаалах мэдлэг, чадварыг тогтмол үнэлэх сертификатжуулалтын систем нэвтрүүлэх;
- Дипломат болон тусгай шууданг биечлэн хүргэгчдэд зориулсан “нууц хамгаалах стандарт сургалт”-ын хөтөлбөр бий болгох зэрэг асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй.

5. Эх сурвалж

- *Монгол Улсын Үндсэн хууль (1992)*
- *Төрийн болон албаны нууцын тухай хууль (2016)*
- *Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам (2017)*
- *Дипломат шуудангийн журам (2019)*
- *Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоол. Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт*
- *Buzan, Barry. People, States and Fear: The National Security Problem in International Relations. (1991)*
- *Б.Батхишиг, “Монгол Улсын төрийн нууцын хадгалалт, хамгаалалтыг боловсронгуй болгох зарим асуудал” докторын судалгааны ажил (2022)*
- *Jerome Frank (Америкийн эрх зүйн философич), "If Men Were Angels: Some Aspects of Government in a Democracy" (1942)*
- *<https://dip.bundestag.de/drucksache/19/19117>, Verschlusssachenanweisung VSA, 2006*
- *https://www.gesetze-im-internet.de/vs-bef_bervo Verschlusssachenbeförderungsverordnung VS-BeförderVO, 2001*